



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.08.06 № 1792  
таний -ны № -т

ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД НАМЫН  
ДАРГА Г.ТЭМҮҮЖИН ТАНАА

Г Хандивын тайлангийн дүгнэлт Г

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргуудад явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох “Дэлхийн монголчууд нам”-ын ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийг 38.8 дахь хэсэгт заасны дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нам нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6, 26.4.6-д заасны дагуу иргэн хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын дээд байгууллага нь хандивын тайланг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын дээд байгууллага хүлээхгүй болно.


**Дүгнэлт**

“Дэлхийн монголчууд нам” 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэж тайлагнаагүй байна.

Хувийг: Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



Z:\Yawsan\Bichig\2021\0805 ADD-26.Docx

40009004

01031972